

# МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН Х АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

## “Б хувилбар”

### ЦАГААН САР

Цагаан сар бол монголчуудын маш том баярын нэг мөн.Билгийн улирлын тооллоор шинэ хуучин он солигдох шинийн нэгний өдрийг баяр ёслолоор тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай.

XIII зууны эхээр Тэмүүжин тархай бутархай олон монгол аймгийг нэгтгэн, Их монгол улсыг байгуулаад гуравдугаар жарны хөхөгчин үхэр жилийн өвлийн сүүл сарын эцэс, улаан барс жилийн хаврын тэргүүн сарын шинэдээр хаан ширээнд суух ёслол болов.Тэр үеэр Их монгол улсын нэгдсэн төрийг нээсэн баярыг шинэ оноо хавар тэмдэглэдэг дорно дахины ихэнх ард түмний нийтлэг ёсоор журамлан, намраас хаврын эхэнд албан ёсоор шилжүүлэн хамтатган тэмдэглэсэн байна.

Ингээд цагаан сар 1206 оноос эхлэн төр ёсны буюу хаврын баярын шинэ утга агуулгаар улам баяжжээ.Чингис хааны анхны цагаан сараар 88 гавьяатыг шагнажээ.

Цагаан сар төр ёсны баяр болсноос хойш үеүдэд хааны зарлиг гарч, хэрэгтэн ялтан нарт төрийн өршөөл үзүүлдэг уламжлал ч буй болжээ.

Богд хаант Монгол улсын үед цагаан сарын үеэр сайд, хан, ван, бэйл, бэйс гүн зэрэг ноёд хутагт хувилгаад, хамба, цорж хийгээд ардууд төрийн ордонд морилон ирж, хаанд бараалхан шинэчлэх, жагсаал ёслол үйлдэх тусгай тогтоосон дэг журамтай байв.

Монголчууд төрсөн өдрийн баяр гэж тусгай зүйл хийдэггүй.Цагаан сараар нас нэмж, өөрөөр хэлбэл төрсөн өдрийн баяраа давхар тэмдэглэдэг эртний заншилтай. Цагаан сар нь цагаан идээний баярын анхны утгаа өдгөө ч хадгалсаар байна.Цагаан сүү,цагаан өнгө нь ариун сайхны аливаа хар хоргүй цайлган сайхны бэлгэ тэмдэг гэдгийг цагаан сар илтгэдэг.

Цагаан сарын шинийн нэгний өглөө гэрийн эзэгтэй эрт босож цай чанаж бууз жигнэн бэлтгэхэд гэрийн бүх хүмүүс шинэ хувцас малгайгаа өмсөж хамгийн ахмад настай аав, ээждээ хадаг эсвэл мөнгө барьж золгоно.Нар цухуймагц золгодог.Дээр цагт өвөг дээдэс шинийн нэгэнд цагаан нэхий дээл өмсдөг байжээ. Харин одоо бол аль өнгөтэй өөдтэйгөөрөө гоёдог болжээ.Үүний дараа настангууд хөөргөөр тамхилж, гэрийн бүсгүй цайг аяга дүүрэн хийж аав,ээж,нөхөртөө,дараа нь хүүхэд багачууддаа өгнө.

Монголын ард түмэн,тэдний соёлд нүүрлэсэн Стлизмын хар шамарга цагаан сарыг бас ч тойрон өнгөрсөнгүй.1930-аад оноос эрх баригчид “Цагаан сар нь лам нарын сайн өдөр, зарц ядуусыг мунхруулан мөлжих өдөр, феодалуудын цэнгэлийн өдөр, феодалын үүсгэсэн харгис зүйл гэхчлэн элдэв нэр хаяг өгч цагаан сарыг хараан гутааж байснаа 1932 оноос хориглосон байна.Харин дэлхийн II дайн дүрэлзэж, Монгол оронд зуд турхан, ган гачиг тохиолдож ард түмний сэтгэл санаа тавгүйхэн байсан 1940-өөд онд тэдний сэтгэлийг түр боловч сэргээхийн тулд хөдөөгийн малчдад цагаан сар тэмдэглэхийг Улсын Бага Хурлаас зөвшөөрчээ.1954 оны 1 дүгээр сарын 26-нд Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг гарч цагаан сар тэмдэглэхийг дахин албан ёсоор хориглосон.Тэгээд 1960 оны 1 дүгээр сард хэсэг хугацааны хориотой байсан Цагаан сарыг “Нэгдэлчдийн өдөр” хэмээх шинэ нэр зүүж хязгаарлагдмал боловч тэмдэглэдэг болжээ.

1988 он хүртэл 70 шахам жил уламжлан ирсэн нөр ёсны их баяр байх эрхээ “хасуулж” үе,үе зэрвэсхэн “тэмдэглэж” иржээ.

Монголчуудын уламжлалт соёл заншлыг хязгаарласан хавчлага хардлагын бараан үүл нэг мянга есөн зуун наяд оны эцсээс өөрчлөлтийн бүлээн салхинд туугдан сэмэрсний ачаар 1988 оноос цагаан сарыг ард нийтээр өнгөрүүлэх сайн цаг эхэлсээр уламжлалт баяр бүх нийтийнх болсон байна. Х.Нямбуу

1. Өгөгдсөн хэсгийн гол санааг хадгалан түүнийг нэмэн дэлгэрүүлж, тайлбарламж эх зохион бичнэ үү? /10 оноо/

Бүтээлчээр ургуулан бодож бичихдээ аль болох оновчтой үг хэллэг, уран яруу дүрслэл, баримт мэдээлэл ашиглаж, найруулга зүйн шаардлага ханган бичихийг зөвлөж байна. Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй. /Үгийн тоо 100-120/

.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

**Цагаан сүү,цагаан өнгө нь ариун сайхны аливаа хар хоргүй цайлган сайхны бэлгэ тэмдэг гэдгийг цагаан сар илтгэдэг....**

2. Эхээс тайлбарлагдаж буй юм, тайлбарлаж буй хэсгийг ялган бичээрэй. / 4 оноо /  
Тайлбарлагдаж буй юм:

a. ....

Тайлбарлаж буй байдал:

b. ....

c. ....

d. ....

3. Өгүүлбэрийн тодруулсан үгсийг ойролцоо утгатай үгээр солин найруулж бичээрэй.

/ 4 оноо /

Их монгол улсыг байгуулаад...өвлийн **сүүл** сарын эцэс...улаан барс жилийн хаврын **тэргүүн** сарын шинэдээр хаан ширээнд суух ёслол болов.

a. ....

b. ....

4. Өгүүлбэрээс холбох үгийг олж, утга үүргийг тайлбарлана уу? /4 оноо /

Дээр цагт өвөг дээдэс шинийн нэгэнд цагаан нэхий дээл өмсдөг байжээ.Харин одоо бол аль өнгөтэй өөдтэйгөөрөө гоёдог болжээ.

a. ....

b. ....

5. Зүй тогтлыг ажиглаад цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу? / 2 оноо/

Өвөг дээдэс, төрийн ордон, хүүхэд багачууд....

a. цагаан сар      б. ард түмэн      в. баяр ёслол      г. бэлгэ тэмдэг

6. “Хар хүзүүний ороолтыг охидууд зүүх дуртай.” гэсэн өгүүлбэрийн найруулгыг засаж бичээрэй. /2 оноо/

.....

7. Дүрслэх хэрэглүүрийг жишээтэй нь харгалзуулна уу? / 5 оноо /

1. Төлөөлөл      а. Ширмэн төмөр малгайтай



## МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН Х АНГИЙН ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

### “Б хувилбар”

#### “ Оюуны лус”

“ Ус ихтэй зохиол” гэж илүү сул үг ихтэй нуршуу зохиолыг хэлцгээдэг. Тэр нь үнэн хэрэг дээрээ зохиогчийн оюуны “ усархгийн” илрэл юм. Тэгвэл “ Бумбын” орон гэгдсэн (монгол нэр нь) оросоор бол “ Водолей” ( ус асгаруулах) хэмээх эрин эхлээд, анхны нэг мөчлөг арван хоёр жилээ наслаад, “ арван гуравны агт араа нь” ургах цаг боллоо. Биеийн шар усыг монголчууд бумба тавьж хатаадаг гэдэг. Тэгвэл “ оюуны шар ус хурчхаад” байгаа нөхцөлд яах вэ гэдэг шинэ асуудал хүн төрөлхтний өмнө шинэ эрин нэлээн чанга дуугаар тавьж эхэллээ. Бараг зуун жил дэлхийн бөмбөрцгийн зургааны нэгээс илүү газар нутаг дээрх олон улсын оюуны цэнэг болж, түүнийх нь “ баадууг” чангалж байсан Орос орон, Оросын марксистууд тэрхүү үзэл бодлоосоо няцаж, “ Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!” гэдэг зээлдмэл уриагаа ном зохиол, сонин хэвлэлээсээ авч хаялаа.

Зуун дамжин шүүмжлүүлж байсан “ капиталист нийгэм” түүний оюуны хөдөлгүүр давамгайлах цаг ирэв үү гэсэн чинь тийм юм мэдрэгдэхгүй байсаар нэгэн мөчлөг өнгөрөв. Уул нь “ Орон бүхний баячууд нэгдэгтүн!” гэсэн сөрөг уриа дэвшүүлмээр юм. Гэтэл тэгсэнгүй. Хөрөнгөт гэгдсэн ертөнцөд “ хямрал гардгаараа гарсаар л, “ хар тосны” өлсгөлөнгөөс болж дайн ч гарсаар байна.

Тэгэх нь ээ хүн төрөлхтний оюун санаанд “ шар ус хурж”, “ лус” үүрлээд, хоёр хаатай, нэг шилбэтэй чөдрөөрөө ухааныг нь чөдөрлөөд авчээ. Тэр чөдрийн баруун талыг нь “ матракаж” гэж (дур татах нь) гэж нэрлээд байна.

Тэр нь радио- телевизийн зар сурталчилгаа, урилга мэтээр “ үзэгч- уншигчаа” тэжээх, тэгснээрээ өөр юм бодохыг “ чөдөрлөх”. Үүнд дэлхий нийт, түүн дотор монголын хэвлэл мэдээлэл хэдийнээ нэгджээ.

Мөнхүү чөдрийн урд талын зүүн хаа нь “ мифомания” гэж (домоглох нь) нэрлэгдээд байгаа. Элдэв хачин үзэгдэл, зохиомол цуу яриа, хуурамч сүжиг бишрэл, гайхмаар хэрэг явдлын мэдэмхийрсэн сурталчилгаагаар “ үзэгч- уншигчаа” ховдсох, тэгснээр бодол санааг нь төөрөлдүүлэх. Үүнд дэлхий нийт мөн түүний дотор монголчууд “ тоон доторх үсэг” гэх шиг л цохиж яваа.

Мөнхүү чөдрийн урт шилбийг “ контестация” гэж (учирлах нь) нэрлээд байгаа. Энэн дээр өрсөлдөөн, хов жив, эсэргүүцэл, заль мэхийн бүх арга хэрэгсэл, гүтгэлэг, булхайцал, авилга, хахууль, хүнд суртал, цөм зангилаатай буюу “ гурамсан чөдөр” гэдэгтэй яг таарахаар нөхцөл орогнож хүмүүсийг (ард иргэд, худалдан авагчид, үйлчлүүлэгчид, шавь нар, эмгэг өвчтөнүүд, зээл авагчид) оюун сэтгэлгээгээр барахгүй эдийн засгийн дарангуйлалд оруулан чөдөрлөх болжээ.

Гурамсан чөдөртэй морь хаашаа ч явж чаддаггүй тэр дорхноо л цөмцөгнөөд байж байдгийг малчин монгол хүн юу эс андах билээ дээ. Гэтэл морь биш Монгол улс

маань дээр дурдсан гурамсан чөдөртэй болчхоод дөрвөн уулын дундаа л “ цөмцөгнөсөөр” Бумбын эриний эхний мөчлөгийг дуусгалаа.

Бумба тавихгүй бол “ оюунд болон биенд хурсан шар ус” юунд ч хүргэж болно гэдгийг (гэхдээ сайн юманд хүргэх нь юу л бол) эртхэн сэхээрэх хэрэгтэй болж байна. Ялангуяа “ чөдрийн урт шилбэнд” шүглэсэн хээл хахууль, хүнд суртал (тэр нь хээл хахууль авах гол хэрэглүүр болсон) заль мэх, булхайцал, хов жив, гүтгэлэг, үгсэл гэхчлэн нэг л мэдэхэд хөнөөл тарьдаг зангилааг задлахгүй бол хол явахгүй нь ээ.

Зангилааг тайлж, бумба тавих эзэн маань ард түмэн билээ. Ард түмэн шаардлагаа, хяналтаа сайжруулж, хуурамч, зальхай, ховсдогчид, гүзээлсэн этгээдүүдийг төрд сонгохгүй байх, сонгосныхоо ясыг нь танимагц эргүүлэн татдаг, сольдог байх, улсын эзэн гэдэг үүрэг, хувь заяагаа бүрэн ухамсарлаж, зөв аргаар бумба тавих аваас лусын хорлолыг зайлуулж чадмуй.

Л. Түдэв

1. “ Оюуны лус” эхэд оюун санааны талаар өгүүлжээ.

Дээрх эхийн гуравласан утга санаанд тулгуурлан хүмүүсийн эв нэгдэл, хамтын хүчийг эргэцүүлэн тунгааж “ Гурван хүний сэтгэл нэгдвэл шар алт болно” сэдвээр 100- гаас доошгүй үгтэй эх зохиож бичээрэй. / 10 оноо/

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

2. Эхийн тайлбарлагдаж буй юм аль цогцолбороор илэрч байна вэ? Ялган зааглаж бичнэ үү. / 4 оноо/

- .....
- .....

3. Дээрх эхийн гол санааг 2 өгүүлбэрээр илэрхийлэн бичээрэй. / 4 оноо/

.....

.....

.....

4. Эхийн гуравласан утга санааг тус бүрд нь 1 өгүүлбэрт багтаан бичээрэй. /4 оноо/

- .....
- .....
- .....
- .....

5. Эхийн “ ... зөв аргаар бумба тавих **аваас** лусын хорлолыг зайлуулж чадмуй” гэсэн өгүүлбэрийн тодруулсан задлаг бүтээврийг ойролцоо утгатай бүтээврээр солин найруулж бичвэл аль нь оновчтой вэ? / 2 оноо/

А. – аад      Б. – жВ. – н      Г. – бал

6. “Хар хүзүүний ороолтыг охидууд зүүх дуртай.” гэсэн өгүүлбэрийн найруулгыг засаж

